



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ
Д.СУМЪЯАБАЗАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: 263727
И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2022.10.19 № 14/4998
танай _____-ны № 01/4942 -т


Хариу хүргүүлэх тухай

Таны 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 01/4942 тоот албан бичигтэй танилцлаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3.9.1-д "Газар зүйн мэдээллийн системд суурилж боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг төлөвлөдөг болно" гэж заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2023 оны төсвийн төслийн хөрөнгө оруулалтын шинэ төсөл, арга хэмжээний саналыг газар зүйн мэдээллийн системийн шинжилгээнд тулгуурлан боловсруулсан.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2023 оны улсын төсвийн төсөлд Нийслэл Улаанбаатар хотод боловсролын салбарт 2023 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлсэн боловч Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2023 оны төсөвт хөрөнгө оруулалтын шинэ төсөл, арга хэмжээг тусгахгүй байх, зөвхөн он дамжин үргэлжлэн хэрэгжиж буй төсөл арга хэмжээг 2023-2024 онуудад бүрэн дуусгах зарчмыг баримтлан шийдвэрлэсэн болно.

Иймд Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх шаардлагатай боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний байршлын саналыг "Нийслэлийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-ний төсөлд тусгуулахаар хавсралтаар хүргүүлж байна.



Д.ЭНХ-АМГАЛАН

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 20 ... оны ... дугаар сарын
1.9-ний өдрийн ... албан бичгийн Хавсралт

№	Аймаг, Нийслэл	Сум, Дүүрэг	Баг/Хороо	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил
1	Улаанбаатар	Баянгол	-	Олон улсын хөтөлбөртэй "Шинэ эхлэл" сургуулийн барилга 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг/
2	Улаанбаатар	Баянгол	24-р хороо	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 240 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 24-р хороо/
3	Улаанбаатар	Баянгол	25-р хороо	Цэцэрлэгийн барилга худалдаж авах, 200 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 25-р хороо/
4	Улаанбаатар	Баянгол	10-р хороо	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 13 дугаар сургууль/
5	Улаанбаатар	Баянгол	18-р хороо	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, Оюуны ундраа цогцолбор/
6	Улаанбаатар	Баянгол	25-р хороо	Сургуулийн барилга, 960 суудал /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 25 дугаар хороо/
7	Улаанбаатар	Баянзүрх	14-р хороо	Цэцэрлэгийн барилга шинээр барих, 240 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 14-р хороо/
8	Улаанбаатар	Баянзүрх	20-р хороо	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 100 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг 20 дугаар хороо /
9	Улаанбаатар	Баянзүрх	4-р хороо	Цэцэрлэгийн барилга шинээр барих, 200 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4-р хороо/
10	Улаанбаатар	Баянзүрх	4-р хороо	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 191-р цэцэрлэг/
11	Улаанбаатар	Баянзүрх	9-р хороо	Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 50 ор /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 9-р хороо, 167-р цэцэрлэг/
12	Улаанбаатар	Баянзүрх	23-р хороо	Сургуулийн барилга худалдан авах, 480 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 142 дугаар сургууль/
13	Улаанбаатар	Баянзүрх	5-р хороо	Сургуулийн барилга буулгаж барих 1500 суудал /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 5-р хороо, 30-р сургууль А байр/
14	Улаанбаатар	Налайх	4-р хороо	Цэцэрлэгийн барилга худалдаж авах, 100 ор /Улаанбаатар, Налайх дүүрэг, 4-р хороо/
15	Улаанбаатар	Сонгинохайрхан	1-р хороо	Сургуулийн өргөтгөлийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 123-р сургууль/
16	Улаанбаатар	Сонгинохайрхан	2-р хороо	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, 42-р сургууль/
17	Улаанбаатар	Сонгинохайрхан	17-р хороо	Сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудал /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг, Өнөр цогцолбор сургууль/
18	Улаанбаатар	Сонгинохайрхан	-	Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургуулийн барилга, 320 суудал /Улаанбаатар/
19	Улаанбаатар	Сүхбаатар	9-р хороо	Үйлдвэрлэл урлагийн политехникийн коллежийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 9 дүгээр хороо/
20	Улаанбаатар	Сүхбаатар	10-р хороо	Цэцэрлэгийн барилга буулгаж барих, 240 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг 10-р хороо, 75-р цэцэрлэг/
21	Улаанбаатар	Сүхбаатар	1-р хороо	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 200 ор /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 16 дугаар цэцэрлэг/
22	Улаанбаатар	Хан-Уул	3-р хороо	Сургуулийн барилга буулгаж барих, 960 суудал /Улаанбаатар Хан-Уул дүүрэг, 15-р сургууль/
23	Улаанбаатар	Хан-Уул	18-р хороо	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 150 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг 18-р хороо/
24	Улаанбаатар	Хан-Уул	1-р хороо	Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 52 дугаар сургууль/
25	Улаанбаатар	Хан-Уул	14-р хороо	Сургуулийн барилга, 640 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 59 дүгээр сургууль/
26	Улаанбаатар	Хан-Уул	13-р хороо	Сургуулийн барилга буулгаж барих, 320 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 26 дугаар сургууль/
27	Улаанбаатар	Хан-Уул	12-р хороо	Сургуулийн барилга, 920 суудал /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, Спортын сургууль/
28	Улаанбаатар	Чингэлтэй	4-р хороо	Сургуулийн барилга буулгаж барих, 960 суудал /Улаанбаатар Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, 5-р сургуулийн А байр/

Т. Амартүвшин



**МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас: (976-11) 32-71-99, Факс: (976-11) 32-21-47
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

2022. 09. 26 № 01/4942

танай _____-ны № _____-т

Төлөвлөгөөний төсөлд санал
ирүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаж улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийслэлд хэрэгжүүлэх арга хэмжээ, барилга байгууламжийн байршлыг "Нийслэлийн 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-ний төсөлд тусгуулах санал, зурган мэдээллийг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн дотор ирүүлэхийг хүсье.

Төлөвлөгөөний төсөлд тусгах газрын зориулалт нь Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний газар ашиглалтын бүсчлэлийн дагуу байхын зэрэгцээ төлөвлөж буй барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдсэн бол давуу тал болно.

Мөн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд дахин төлөвлөлт хийгдэх газар болон бусдын эзэмшил, өмчлөл, ашиглалтын газарт барилга, байгууламж барихаар төлөвлөж байгаа бол газар чөлөөлөх нөхөх олговрын хэмжээг тогтоож, төсөвт тусгасан байх шаардлагатайг уламжилъя.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Д.СУМЪЯАБАЗАР

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Карт №
МАНУТ

111020005817